

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР****Санамж:**

1. Эхийг анхааралтай уншиж, ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

*Намар*

*Намрын шар наран над дээр, чам дээр тусна  
 Найган найгах улиралд нь бид бас найгана  
 Буга хандгай урамдаж, уул усыг баясгахад  
 Үхэр шар мөргөлдөн, малчин хүнийг зугаацуулна  
 Сайхан огторгуйн дунд нимгэн цагаан үүл нүүхэд  
 Идэр залуус алс газрыг сонирхон сурахаар одно  
 Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр, дув дуугүй урсахад  
 Түүний дотроо саран мишээж, янагийн үлгэрийг сэмээр өгүүлнэ  
 Өглөөний хяруу сувдын адил гялтганан бууралтахад  
 Гадна сойсон морь бүг бүг, бөн бөн чичирнэ  
 Гэрийн эзэн эртлэн, үнэг чоныг гөрөөлөхөөр одоход  
 Эхнэр хүүхэд аарц нэрж, түүнийг хүлээнэ  
 Урьхан хонгор салхин өвс модыг намилзуулахад  
 Хөгшин залуу хүмүүсийн сэтгэл бөн бөн бөмбөрнө  
 Шарласан модны навч хоёр нэгээр унахад  
 Сэтгэлийн доторх уйтгарт явдал хааяа хааяа бодогдоно (Д.Нацагдорж)*

1. Эх нь тоочимж болохыг баталсан хэсгийг олоорой.
  - A. Юмс үзэгдлийн гол шинжийг нарийн дэс дараалалтай зураглан бичжээ.
  - B. Хэрэг явдлыг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт хүүрнэн бичжээ.
  - C. Хэрэг явдлын бодомжийн харьцаанаас шинэ дүгнэлт гаргажээ.
  - D. Агуулга нь баримт жишээнд тулгуурлажээ.
  - E. Шалтгаан, үр дагавар, дүрэм тодорхойлолтод тулгуурлажээ.
2. **“Малчин хүнийг зугаацуулна.”** гэсэн өгүүлбэрийн өгүүлэхүүнийг асуух өгүүлбэрийн өгүүлэхүүн болгон хувиргасан хэсгийг олоорой.
 

A. зугаацууллаа	B. зугаацуулж уу	C. зугаацууллаа даа
D. зугаацуулсангүй	E. зугаацуулаарай	
3. Дагуул үг нь үйл үгээр илэрсэн холбоо үгийг олоорой.
 

A. уул усыг баясга	B. зөөлөн зөөлнөөр урс	C. бөн бөн чичир
D. өвс модыг намилзуул	E. гялтганан бууралт	
4. **“Найган найгах улиралд нь бид бас найгана.”** гэсэн өгүүлбэрийг шууд утга санаагаар хувиргасан хэсгийг олоорой.
  - A. Намрын бороо зөөлөн шиврэхэд аав минь дуртай.
  - B. Айраг шаагих намар, ажлын цуурай, замын тоос тэнгэрт хадна.
  - C. Налгар намрын цагт хүн бүрийн сэтгэл тайван.
  - D. Нарийн хяруу гадаа унаад, намрын өглөө жихүүн байна.
  - E. Урт сайхан намар унага унан чавхдана.
5. Дараах өгүүлбэрүүдээс эхийн санаанд холбогдолгүй хэсгийг олоорой.
  - A. Өнөр сайхан төл баян хотыг чимэхэд
  - B. Буга хандгай урамдаж, уул усыг баясгахад

- C. Өглөөний хяруу сувдын адил гялтганан бууралтахад  
D. Урьхан хонгор салхи өвс модыг намилзуулахад  
E. Шарласан модны навч хоёр нэгээр унахад
6. **“Шарласан модны навч хоёр нэгээр унахад ...”** гэдэгтэй ойролцоо санаат хэлцийг олоорой.  
A. Цаг нь ирвэл, цасан дээр түймэр шатна  
B. Уулын мод урттай, богинотой  
C. Хүний зөөлнийг хүн олох, модны зөөлнийг тоншуул олох  
D. Өнгө өнгөөрөө байдаггүй, өвс ногооноороо байдаггүй  
E. Өмх модонд үндэсгүй, үхэл зовлонд нүдгүй
7. Эхийн гол санааг илэрхийлсэн холбоо үгийг олоорой.  
A. Нимгэн цагаан үүл  
B. Гадна сойсон морь  
C. Хөгшин залуу хүмүүс  
D. Тунгалаг мөрөн  
E. Найган найгах улирал
8. Зүйлчилсэн утгаараа бусдаас ялгаатай хэсгийг олоорой.  
A. Найгах улирал  
B. Хонгор салхи  
C. Өглөөний хяруу  
D. Цагаан үүл  
E. Өвс мод
9. Эхийн сэдвийг тодорхойлсон өгүүлбэрийг олоорой.  
A. Буга хандгай урамдаж уул усыг баясгана.  
B. Намрын шар наран над дээр, чам дээр тусна.  
C. Идэр залуус алс газар сурахаар одно.  
D. Гэрийн эзэн эртлэн босож, үнэг чоно гөрөөлөхөөр одно.  
E. Үхэр шар мөргөлдөн, малчин хүнийг зугаацуулна.
10. **“Түүний дотроо саран мишээж...”** гэсэн өгүүлбэрийг найруулгын ерийн зэрэгт хувиргасныг олоорой.  
A. Сарны туяаг залгилж  
B. Сарны гэрэл тусаж  
C. Сарны зөөлөн шаргал өнгө навчсанд хувилж  
D. Саран авхай инээмсэглэж  
E. Сарны туулай бүжиж
11. Эхэд өгүүлэгчийн дотоод сэтгэлийн ямар үнэлэмж, өнгө аяс илэрсэн бэ?  
A. Үйл байдалд эргэлзэж тээнэгэлзсэн  
B. Үйл байдалд санаашран, уйтгарласан  
C. Үйл байдлыг тааварлан барагцаалсан  
D. Үйл байдлын таагүйг илэрхийлсэн  
E. Үйл байдал сэтгэлд зохистойг илэрхийлсэн
12. **“Өглөөний хяруу сувдын адил гялтганан бууралтахад Гадна сойсон морь бүг бүг, бөн бөн чичирнэ”** гэдгийн мөр хоорондын холбоосыг солин найруулахад аль нь тохирох вэ?  
A. үед  
B. харин  
C. мэт  
D. төлөө  
E. эсвэл
13. **“Сайхан огторгуйн дунд нимгэн цагаан үүл нүүхэд...”** гэдгийг эрдэм шинжилгээний найруулгад зөв хувиргасан хэсгийг олоорой.  
A. Бараан өнгийн суурьтай зузаан давхаргыг хамарсан бөөн үүл.  
B. Бага нягттай үүл нь агаарын урсгалаар зөөгдөх нь элбэг.  
C. Үүлний орших өндөр янз бүр, хамгийн дээд хил нь экваторт 18 км.  
D. Усны уур өтгөрөх явцад агаарт үүл үүснэ.  
E. Үүлний өндөр нь улирлын өөрчлөлтөөс хамаарна.
14. Эхэд байгаа **“Урьхан хонгор салхи”** гэсэн адилтгасан дүрслэлийн шинжийг олоорой.  
A. халуун  
B. ширүүн  
C. сэрүүн  
D. хүчтэй  
E. хүйтэн
15. Эхээс **“Эхнэр хүүхэд түүнийг хүлээнэ.”** гэсэн өгүүлбэрийг дэлгэрүүлсэн цагийн байц буюу захын дэлгэрүүлэгч гишүүн өгүүлбэрийг олоорой.  
A. Гэрийн эзэн эртлэн  
B. Өглөөний хяруу бууралтахад  
C. Эхнэр хүүхэд аарц нэрж  
D. Гэрийн эзэн одоход  
E. Үнэг чоныг гөрөөлөхөөр

16. **“Сэтгэлийн доторх уйтгарт явдал хааяа хааяа бодогдоно.”** гэсэн өгүүлбэрийн үйлийн хамжсан тодотгол гишүүнийг салаалан хувиргасныг олоорой.  
 А. санагдана      В. гунигт      С. үе үе      D. учрал      E. сэтгэлд байсан
17. Аль хэсэг нь эхэд хүний дотоод сэтгэлийн өөрчлөлт хувирлыг илэрхийлээгүй вэ?  
 А. Бид бас найгана.      В. Идэр залуус сурахаар одно.      С. Малчин хүнийг зугаацуулна.  
 D. Сэтгэл бөн бөн бөмбөрнө.      E. Уйтгарт явдал хааяа хааяа бодогдоно.
18. **“Найган найгах улиралд нь бид бас найгана.”** гэдгийг **“Найган найгах тарианы улиралд нь бид бас найгана.”** гэж хувиргавал эхийн найруулгад өөрчлөлт гарах уу?  
 А. Үг буруу сонгосон алдаа болно.      В. Үг илүүдэж шүлгийн айзам хэмнэл алдагдана.  
 С. Үг дутсан алдаа болно.      D. “Тарианы улирал” гэдэг нь учир зүйн алдаа.  
 E. Үр тарианы улирал тул оновчтой.
19. Намрын улиралд холбогдолгүй хэсгийг олоорой.  
 А. Урьхан хонгор салхин      В. Буга хандгай урамд      С. Өглөөний хяруу гялтгана  
 D. Шарласан модны навч      E. Зургаан мичид орой дээр
20. Эхэд эсрэг утгатай байгаа үгсийг олоорой.  
 А. бөмбөрөх – зугаацах      В. урсах – өгүүлэх      С. бууралтах – чичрэх  
 D. нүүх – одох      E. баясгах – зугаацуулах
21. **“зугаацуулна”** гэдгийн утгат хэсгийг зөв тайлбарласныг олоорой.  
 А. зугаа – идэвхтэй үйл язгуур, үгийн үүсмэл үндэс  
 В. зугаацуул – идэвхтэй нэр язгуур, үйлийн үндэс үүсгэх дагавар авсан, үйлдэлцэх хэвд  
 С. зугаац – идэвхтэй нэр язгуур, үйлийн үндэс үүсгэх дагавар авсан  
 D. зугаацуулна – үйл үг, үүсмэл бус, анхдагч үндэс, үйлдэгдэх хэвд  
 E. зуга – идэвхгүй язгуур, үйлийн үндэс үүсгэх дагавар авсан
22. Өгүүлбэрийн цэгийн оронд жинхэнэ нэрийг тохируулан нөхөөрэй.  
**Ат орилон, ..... шаргиж Пунсаагийнх ачаална.**  
**Алаг нүдэн Пунсаа гарыг минь байн байн атгана. (Б.Л)**  
 А. дотор      В. өглөө      С. үе үе      D. унь      E. гадаа
23. Дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.  
 Үйл үг, үүсмэл, өөрөө үйлдэх хэв, энгийн үйлдэх байдалд, ирээдүй цагаар тодотгон холбох нөхцөл (цагт нэрийн ирээдүй цаг), өгөх оршихын тийн ялгалд  
 А. найгана      В. зугаацуулна      С. гялтганан      D. бууралтахад      E. бодогдоход
24. Дараах таван үгээс төрөл биш утгат үгийг олоорой.  
 А. амла      В. амар      С. амгай      D. амт      E. амд
25. Эхийн дараах хэсэгтэй ойролцоо санаат өгүүлбэрийг олоорой.  
**Урьхан хонгор салхин өвс модыг намилзуулахад**  
**Хөгшин залуу хүмүүсийн сэтгэл бөн бөн бөмбөрнө**  
 А. Намрын салхи сэвэлзэхээр нартын жамыг ухаарах юм даа.  
 В. Өвсний толгой халиурахын дундуур түүний гэрийн утаа цэнхэрлэн холдоно. (Д.Н)  
 С. Намрын навчис шар – р хийнэ, шаргиснаа хийснэ. (Ч.Д)  
 D. Намираа цэнхэр бороо шивэрсэн намрын хонгор өдрөө дурс даа чи.  
 E. Алтан навчис хийслээ дээ, есөн сарын нэгэн бол ерөөсөө бидний баяр даа.
26. Дараах хэсэгт харь үг хэрэглэснийг хэрхэн дүгнэх вэ?  
 “За би нэг сайн эр болж, нэг амьсгаагаар “гучин хоёр трейд” хэлье ээ. Интер трейд, Алтай трейд, Чингис трейд, Очир трейд, Цайны зам трейд, Таван трейд ... Ээ харла аа, хорин дөрөв хүргээд алдчихлаа. “Лонх” гэвэл болдог юм, “Трейд” гэхээр тээглээд явдаггүй шүү. (Д.Ө)

- A. Харь үг хэлний хөгжлийг тодорхойлж байгааг сайшаажээ.  
 B. Харь үгийг утга зохиолын хэлний аль ч найруулгад чөлөөтэй хэрэглэнэ.  
 C. Хаяг харийншиж, хэл хүнийшиж байгааг егөөджээ.  
 D. Харь үгийг уран зохиолын найруулгад огт хэрэглэхгүй.  
 E. “Гучин хоёр цагаан лонх” – ыг шүүмжилжээ.
27. Дараах хэсгийн тодруулсан бүтээврийн (- хан<sup>4</sup>) баймж утгатай хамгийн ойр хэсгийг олоорой.  
 “Урь**хан** хонгор салхин өвс модыг намилзуулахад  
 Хөгшин залуу хүмүүсийн сэтгэл бөн бөн бөмбөрнө”
- A. Аавгүйхэн ботго нь араар тэнээд буйлна  
 B. Тавьхан лангийн үнэтэй миний ээж хаачив?  
 C. Голын хэдэн нарс ав адилхан өндөр, ав адилхан намхан ургажээ.  
 D. Хөвсгөрхөн цагаан үүл нь хөвөлзөнхөн нүүдэллэнэ.  
 E. Таван зуугаадхан хонийг чинь нүдэлж цөхөөд байх юу байхав дээ.
28. Дараах өгүүлбэрийн утга санааг эсрэг санаагаар солин найруулахад цэгийн оронд дарааллаараа тохирох хэсгийг ол.  
 Олны тусыг бодогч мэргэдийн санаа сайн. Олны тусыг ... бодогч мэргэдийн санаа сайн ...
- A. битгий, на      B. маш, аарай      C. үл, гүй      D. эс, лаа      E. гүй, жээ
29. Утга төгс өгүүлбэр бүтээхэд, цэгийн оронд аль бүтээвэр нь дарааллаараа тохирох вэ?  
**Өндөр уул ... ын орой ... будан хүдэн зугаа...на.**
- A.- с, - д, - ц,    B. – ууд, - уур, -л,    C.- нар,-г, -р,    D. - д, - ын, - ц,    E. - чин, -руу, - ц,
30. “- вий” - г сануулан хориглож, болгоомжлох баймж утгат өгүүлбэрт хэрэглэснийг олоорой.  
 A. Эрдэнэ уулын бараа нь илхэн тодорхой харагдана вий  
 B. Улайх нарны наахнуур униар будан татаа вий  
 C. Хайртай таныгаа ирнэ гэж, бардсаар харина гэж дуулна вий.  
 D. Наран булгийн эхнээс усны тунгалаг урсана вий.  
 E. Эргүүлэн төрүүлж болохгүй энэ л биеэ эндүүрэх вий
31. Дараах хэсэгт нэрлэхийн тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ?  
**Буга хандгай урамдаж, уул усыг баясгахад  
 Үхэр шар мөргөлдөн, малчин хүнийг зугацуулна**
- A. 6      B. 3      C. 4      D. 5      E. 7
32. Цэгийн оронд зөв бичгийн дүрмийн алдаагүй үгийг нөхөж бичээрэй.  
**Баавгай цээжээ ..... ойн гүн рүү оров.**
- A. хүржгнүүлэн    B. хүржэгнүүлэн    C. хүржигинүүлэн    D. хүржигнүүлэн    E. хүржгэнүүлэн
33. “Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр дув дуугүй урсахад...” гэсэн өгүүлбэрт үйлдэхийн тийн ялгалын нөхцөл ямар утгатай байна вэ?
- A. Үйлийн орон зай      B. Үйлийн шинж байдал      C. Үйлэнд өртөх юм  
 D. Үйлийн шалтгаан заах    E. Үйлийн явдал хам болох
34. Ц.Дамдинсүрэн “Хэлдэг гурав, хийдэг ганц” өгүүллэгийн Сүрмаагийн дүрийг тодорхойлсныг олоорой.
- A. Ажил сайтын амьдрал сайн  
 B. Залхуу хүн завагтаа хүрэхгүй  
 C. Эрдэмт хүн даруу их мөрөн дөлгөөн  
 D. Ишигний эвэр ургаж эхийн дэлэн чичих  
 E. Муу хүний үг мангираас гашуун

35. Б.Лхагвасүрэн “Боржигоны бор тал” шүлгийн дараах мөрийн цэгийн оронд дарааллаараа тохирох хэсгийг олоорой.

..... эрхэмсэг ..... туйл  
 ..... царайчилсан газрын ..... хормой минь

- A. Эгэл, нандин бүхний, сар нар, буянтай
- B. Цэвэр, сайхан бүхний, бороо хур, хөрстэй
- C. Ариун, үнэт бүхний, цас бороо, амьтай
- D. Сайхан, ариун нандины, хур нар, устай
- E. Нандин, эгэл боргилын, нар хур, саальтай

36. “Монголын нууц товчоо” зохиолд “Би сайн нөхөр чамайг мунгинаж явна гэж тус болохоор ханилж явсан билээ. Би олз эрсэнгүй. Би Наху баяны ганц хөвүүн тул миний эцгийн зөөсөн хураасан хөрөнгө надад элбэг хүрнэ.” гэсэн үгийг хэн хэлсэн байдаг вэ?

- A. Бэлгүтэй
- B. Зэлмэ
- C. Жамуха
- D. Боорчи
- E. Борохул

37. Монгол бичгийн эхийг уншаад, зөв хөрвүүлгийг олоорой.

ᠠᠷᠢᠯᠢᠭᠦ ᠬᠠᠵᠠᠷᠯᠠᠵᠢ  
 ᠰᠢᠨᠠᠭᠤ ᠰᠡᠲᠦᠭᠡᠯᠢᠭᠡᠢ  
 ᠲᠡᠪᠴᠢ

- A. Эрлийг хазаарлаж шунаг сэтгэлийг тэвч
- B. Эрэл хүслээ хазаарлан шунахай сэтгэлийг тэвч
- C. Эрэл хүслээ хазаарлаж шунаг сэтгэлийг тэвч
- D. Эрлээ хазаарлавал шуналын сэтгэлийг тэвчинэ
- E. Эрэл хүслийг хазаарлан хүний сэтгэлийг тэвч

38. Цэгийн оронд тохирох дагаврыг олоорой. (Хоёр үгэнд ижил дагавар тохирно.)

- A.
- B.
- C.
- D.
- E.

ᠠᠷᠢᠯᠢᠭᠦ ᠬᠠᠵᠠᠷᠯᠠᠵᠢ  
 ᠰᠢᠨᠠᠭᠤ ᠰᠡᠲᠦᠭᠡᠯᠢᠭᠡᠢ  
 ᠲᠡᠪᠴᠢ

ᠠᠷᠢᠯᠢᠭᠦ ᠬᠠᠵᠠᠷᠯᠠᠵᠢ  
 ᠰᠢᠨᠠᠭᠤ ᠰᠡᠲᠦᠭᠡᠯᠢᠭᠡᠢ  
 ᠲᠡᠪᠴᠢ

39. Монгол бичигт “-аарай<sup>4</sup>” нөхцөл залгахад холбох эгшиг авах үг аль вэ?

- A. Нүүгээрэй
- B. Суугаарай
- C. Бичээрэй
- D. Босоорой
- E. Хийгээрэй

40. “Хээр хөдөөд таван хошуу мал бэлчинэ.” гэсэн өгүүлбэрийн тодоор бичсэн үг аль нь вэ?

- A.
- B.
- C.
- D.
- E.

ᠬᠡᠭᠡᠷ ᠬᠡᠳᠡᠭᠡᠳᠡ ᠲᠠᠪᠠᠨ ᠬᠣᠰᠤᠭᠤ ᠮᠠᠯ ᠪᠡᠯᠴᠢᠨᠡ  
 ᠬᠡᠭᠡᠷ ᠬᠡᠳᠡᠭᠡᠳᠡ ᠲᠠᠪᠠᠨ ᠬᠣᠰᠤᠭᠤ ᠮᠠᠯ ᠪᠡᠯᠴᠢᠨᠡ  
 ᠬᠡᠭᠡᠷ ᠬᠡᠳᠡᠭᠡᠳᠡ ᠲᠠᠪᠠᠨ ᠬᠣᠰᠤᠭᠤ ᠮᠠᠯ ᠪᠡᠯᠴᠢᠨᠡ  
 ᠬᠡᠭᠡᠷ ᠬᠡᠳᠡᠭᠡᠳᠡ ᠲᠠᠪᠠᠨ ᠬᠣᠰᠤᠭᠤ ᠮᠠᠯ ᠪᠡᠯᠴᠢᠨᠡ  
 ᠬᠡᠭᠡᠷ ᠬᠡᠳᠡᠭᠡᠳᠡ ᠲᠠᠪᠠᠨ ᠬᠣᠰᠤᠭᠤ ᠮᠠᠯ ᠪᠡᠯᠴᠢᠨᠡ

**ХОЁРДУГААР ХЭСЭГ: ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР**

- Санамж:** 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.  
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой

**2.1. Хэлцийн утгыг тунгаан цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.**

- |   |                                 |
|---|---------------------------------|
| a. Дорнод уулын оройгоос цацарч байгаа нарны гэрэлд ивээгдсэн Тамирын хөндийн бөөн бөөн гялалзсан хар толбо ..... шиг өнхрөн тоглож байв. (Ч.Л) | 1. лянхуа цэцэг                 |
| b. Хуучны хуульч түшмэлийн нүдээр үзвэл энэ айлтгалын үг найруулга нь ..... багтамгүй найруулсан юм байна даа. (Б.Р)                            | 2. намрын хамхуул               |
| c. Төмөрийн зүрх баяр догдлолоор дүүрч сэтгэл нь доргиж байгаа ..... шиг чичирч байв.   | 3. бүдүүн өвс                   |
| d. Энгийн номхон ардаас ..... авсан хүнийг хамгийн хатуу цээрлүүлнэ гэж Сүхбаатар өндөр дуугаар хэлэв. (Ч.Л)                                    | 4. чанга татсан утас            |
| e. .... шавраас гардаг гэгчээр Ням, Хишигт хоёроос ийм эрдэнэ төрдөг байжээ. (Ч.Л)  | 5. сэтэрхий зүү, сиймхий самбаа |

**2.2. Оновчтой харгалзуулан дүрслэх ур маягийг бүтээгээрэй.**

- |                            |          |
|----------------------------|----------|
| a. Гүүний айраг шиг сэрүүн | 1. говь  |
| b. Улайссан тогоо шиг      | 2. агаар |
| c. Хангай шиг түшигтэй     | 3. уул   |
| d. Хаврын тэнгэр шиг       | 4. ааш   |
| e. Наранд эрхлэн дуниарсан | 5. аав   |

**2.3. Нэг зохиолчийн хоёр бүтээлийг харгалзуулаарай.**

- |                               |                     |
|-------------------------------|---------------------|
| a. “Цагаан сар ба хар нулимс” | 1. “Монгол хэл”     |
| b. “Би хаана төрөө вэ?”       | 2. “Шаргачин”       |
| c. “Тунгалаг тамир”           | 3. “Хоёр цагаан юм” |
| d. “Нууцыг задруулсан захиа”  | 4. “Од”             |
| e. “Буурал эжий минь”         | 5. “Тэхийн зогсоол” |

**2.4. Дараах үгсийг утгын тайлбартай нь зөв харгалзуулаарай.**

- |                  |   |
|------------------|---|
| a. Майхны ваадан | 1. Майхны хоёр голын хойд урд хоёр хошуу      |
| b. Майхны шувуу  | 2. Майхны хаяа тойрон хийсэн унжлага бөс      |
| c. Майхны хэц    | 3. Майхны багана                              |
| d. Майхны хаяавч | 4. Майхны ам талыг нээх, зөрүүлэх хоёр хошуу  |
| e. Майхны шанаа  | 5. Майхны олон уузварт бэхлэн хийсэн олс дээс |